



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР

2026 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх,
хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Сүүлийн 5 жил улсын хэмжээнд үерийн 562 тохиолдол бүртгэгдэж, 22 хүн (хүүхэд 4) амь насаа алдаж, 42.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан ба усны ослын 559 тохиолдол бүртгэгдэж, 454 хүн (хүүхэд 100) амь насаа алдсан байна. Шалтгаан нөхцөлийг судлан үзэхэд иргэд амралт зугаалгаар явахдаа архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн, бага насны хүүхдэд тавих хараа хяналтаа сулруулсан, баталгаагүй зам, гарц гарамгүй хэсгээр болон үертэй үед гол гаталсан гэх шалтгаанууд голлож байна.

Цаг уурын байгууллагаас гаргасан 2026 оны дулааны улирлын төлөв байдлын мэдээгээр 6-8 дугаар сард ихэнх нутгаар олон жилийн дунджаас дулаан, хэт халах төлөвтэй байгаа бөгөөд агаар, хөрсний хэт халалтаас шалтгаалан гэнэтийн үерийн аюул тохиолдох эрсдэл өндөр байна.

Иймд мэргэжлийн байгууллагуудаас гаргасан мэдээллийг иргэдэд өргөн цар хүрээтэй хүргэж, болзошгүй үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, салбар хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлж, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, нэн шаардлагатай зохион байгуулалт болон төсөв хөрөнгийг шийдвэрлэх чиглэлээр Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1.4} дэх заалтыг үндэслэн Улсын онцгой комиссын гишүүд, холбогдох агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт ДААЛГАХ НЬ:

Нэг. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Э.Бат-Амгаланд:

1.1. Үерийн далан, суваг, шуудууны төлөвлөлт, ашиглалтад хяналт тавьж, засвар үйлчилгээ, сэргээн босголтын ажлыг цаг алдалгүй хийх, холбогдох мэргэжлийн байгууллагууд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах,

1.2. Салбарын хэмжээнд бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, харьяа байгууллагуудыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, төсөв хөрөнгийг шийдвэрлэх.

Хоёр. Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Э.Батшугарт:

2.1. Болзошгүй үерийн үед ажиллах эрүүл мэндийн байгууллагын хүн хүч, техник, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг

хангуулж, иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг шуурхай, тасралтгүй үзүүлэх, салбарын бүх шатны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгах бодис материалын нөөцийг бүрдүүлэх,

2.2. Үерийн дараа үүсэж болзошгүй халдварт өвчний эрсдэлийн үнэлгээг хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, мэдээ мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх, халдваргүйтгэлийн арга хэмжээг чанартай зохион байгуулах.

Гурав. Зам, тээврийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Дэлгэрсайханд:

3.1. Авто зам, замын байгууламж, төмөр замын дагуу үерийн эрсдэлийн үнэлгээ хийж, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, засвар үйлчилгээг төлөвлөгөөний дагуу чанартай хийх, тээврийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх,

3.2. Үерийн улмаас эвдэрч, нурсан зам, гүүрийг богино хугацаанд сэргээн засварлахад шаардлагатай эд материал, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлж, хүн хүч, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах,

3.3. Голомтод үүрэг гүйцэтгэх тусгай зориулалтын техник, механизмаар хангах төлөвлөлтийг хийж, холбогдох аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах.

Дөрөв. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Ц.Сандаг-Очирт.

4.1. Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, иргэдэд мэдээ мэдээлэл хүргэх чиглэлээр харьяа байгууллага болох Цаг уур, орчны шинжилгээний газар, Усны газрыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах, улсын албаны болон харьяа байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох,

4.2. Гол мөрний ай сав газруудад суурьшсан болон үйл ажиллагаа явуулж иргэн, хуулийн этгээдэд хяналт шалгалтыг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг нутгийн захиргааны байгууллага болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

Тав. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Ч.Номинд:

5.1. Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран саадгүй шуурхай хүргэх бодлогын болон техникийн шийдлийг гаргах, хөгжүүлэх,

5.2. Эрт зарлан мэдээллийг системийг сайжруулах, хөгжүүлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх, дэмжлэг үзүүлэх, болзошгүй үерийн гамшгийн үед харилцаа холбооны тасралтгүй, найдвартай байдлыг хангуулах, харьяа байгууллагуудын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлэн байдлын нөөц бүрдүүлэх.

Зургаа. Батлан хамгаалахын сайд,

Улсын онцгой комиссын орлогч дарга Д.Батлутад:

6.1. Үерийн гамшгийн үед дайчилгаагаар ажиллах цэргийн албан хаагчдын болон инженерийн техник, тоног төхөөрөмжүүдийн бэлэн байдлыг хангуулж, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх,

6.2. Үерийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийн чиглэлээр Барилга, хот байгуулалтын яам, Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.

**Долоо. Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуянд:**

7.1. Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны материал, сэрэмжлүүлэх мэдээллийг бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үүрэн холбооны сүлжээгээр иргэдэд шуурхай хүртээмжтэй хүргэх,

7.2. Холбогдох мэргэжлийн болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр сургалт, өдөрлөг нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах,

7.3. Үерийн эрсдэлтэй бүсэд суурьшсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдэд холбогдох улсын алба, нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулж улсын хяналтын байцаагчийн албан шаардлага нэг бүрчлэн хүргүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах,

7.4. Цагдаагийн байгууллага, нутгийн захиргааны байгууллагатай хамтран усны ослоос урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүл ажиллуулах арга хэмжээг зохион байгуулах,

7.5. Монгол Улсын болон аймаг, нийслэл, гамшгаас хамгаалах улсын албадын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих,

7.6. Үерийн гамшгийн үед ажиллах улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудаас дайчлан ажиллуулах хүн хүч, техник, багаж хэрэгслийн судалгааг бодит байдлаар гаргаж, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх,

7.7. Байгууллага хоорондын харилцан ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах шуурхай штабыг ажиллуулах.

**Найм. Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал Ж.Болдод:**

8.1. Үерийн гамшгийн үед олон нийтийн хэв журам сахиулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, авто тээврийн хөдөлгөөн зохицуулалт хийх, үерийн гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр салбарын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх,

8.2. Үерийн гамшгийн үед ажиллах хүн хүч, техник тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх.

**Ес. Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Э.Баттулгад:**

9.1. Цаг агаарын болон шар усны үерийн мэдээ, сэрэмжлүүлэг мэдээллийг бүх төрлийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд хүртээмжтэй, шуурхай тогтмол хүргэх, холбогдох байгууллагуудыг мэдээ мэдээллээр тогтмол хангаж, мэдээлэл дамжуулах системийг сайжруулах,

9.2. Цаг уурын байгууллагаас гаргаж буй богино, дунд, урт хугацааны урьдчилсан мэдээний таарцыг дээшлүүлэх, цаг агаарын гаралтай аюулт гамшигт үзэгдлийн нөлөөллийн талаар зөвлөмж, мэдээллээр хангах.

Арав. Геодези, усны барилга байгууламжийн газрын дарга

Б.Бямбасайханд:

10.1. Үерээс болон хөрсний уснаас хамгаалах барилга байгууламж, ус зайлуулах шугам сүлжээний засвар, арчлалтыг тогтмол хийж, гүйцэтгэх, хэвийн ажиллагааг хангах, болзошгүй үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх,

10.2. Үерийн үед ажиллах хүч хэрэгсэл, техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, нөөцийг бүрдүүлэх, шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх.

Арван нэг. Ус сувгийн удирдах газрын дарга Ц.Төрхүүд:

11.1. Үерийн гамшиг тохиолдсон үед иргэдийг ундны усаар хангах төлөвлөлтийг тодотгож, цэвэр усаар хангах зориулалттай байгууламж, ус тээвэрлэх автомашин, зөөврийн ус түгээх цэгүүдийн хэвийн ажиллагааг хангаж, засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай сэлбэг хэрэгсэл, эд материал, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, шатах тослох материалын нөөцийг бүрдүүлэх.

Арван хоёр. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт :

12.1. Бүх шатны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хүн, хүч техник хэрэгслийн бодит судалгаанд үндэслэн тодотгол хийх, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, тусгайлан үерийн гамшигийн үед дайчлан ажиллуулах хүнд даацын техник, машин механизм, ус соруулах төхөөрөмжүүдийн судалгааг нарийвчлан хийж, бүртгэлжүүлэх, урьдчилсан гэрээ хэлцэл хийж бэлэн байдлыг хангах,

12.2. Суурьшлын бүсийн ойролцоо байдаг гол, нуур, уулархаг газруудад эрсдэлийн үнэлгээ хийх, үерийн эрсдэл бүхий газруудад суурьшсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамгаалах чиглэлээр инженерийн болон инженерийн бус арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран төлөвлөж, хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авах,

12.3. Мэргэжлийн байгууллагатай хамтран иргэдэд үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх, сургалт дадлагын ажлыг шаардлагатай газруудад үе шаттай зохион байгуулах, аюул бүхий газруудыг тэмдэгжүүлэх,

12.4. Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллийг хүргэх, эргүүл хяналт хийх, авран хамгаалах чиглэлээр орон нутгийн Онцгой комисс, шуурхай штаб, мэргэжлийн анги, Онцгой байдлын албанд дутагдалтай байгаа техник, багаж, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээг авах,

12.5. Гол, мөрний эрэг, үерээс хамгаалах далан, суваг, шуудуу орчим барилга, хот байгуулалт, цагдаа, онцгой, боловсролын болон хүүхэд хамгааллын байгууллага, улаан загалмай нийгэмлэгтэй хамтран үзлэг шалгалт зохион байгуулах, гарц, урсцыг нээх, шаардлагатай инженерийн болон инженерийн бус арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх,

12.6. Үерийн эрсдэл бүхий голын голдирол, гуу жалга газар эрсдэлийн үнэлгээ хийж, үерт өртөж болзошгүй айл өрх, аж ахуйн нэгжүүдэд аюултай бүсээс нүүн шилжих улсын байцаагчийн албан шаардлагыг нэг бүрчлэн өгч, үерийн гамшгаас учирч болзошгүй хор хохирлыг тайлбарлан таниулж, мэдээлэл сурталчилгаа, заавар зөвлөмжөөр хангаж, аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх,

12.7. Шаардлагатай үед үерийн гамшгаас хамгаалах байгууллага хоорондын харилцан ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий шуурхай штабыг байгуулан ажиллуулах,

12.8. Үерийн гамшиг тохиолдсон үед иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэх газар, түр хорогдох байрны бэлэн байдлыг хангуулах, ус, хүнс,

эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, шатах, тослох материал, зам, гүүр, далан суваг засварлахад шаардлагатай материалын нөөцийг бүрдүүлэх,

12.9. Амжиж анхааруулах системийг хөгжүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, үүрэн холбооны оператор компаниудтай хамран “Багц мессеж” үйлчилгээг ашиглан мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх,

12.10. Голын голдирол, үер урсаж болзошгүй газруудыг санаатай болон санамсаргүй байдлаар хааж, нарийсгаж боосон газруудыг тогтоож, урсцыг чөлөөлөх арга хэмжээг авах,

12.11. “What3words” байршил тогтоох системийг ашиглан иргэн аж ахуйн нэгж, байгууллага бүрийн байршлыг тогтоох, мэдээлэл дамжуулах.

Арван гурав. Албан даалгаврыг хэрэгжүүлж, тайлагнах:

13.1. Албан даалгаврыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд хэрэгжүүлж, тайланг сар бүрийн эхний 7 хоногт Улсын онцгой комиссын Ажлын албанд албан бичгээр болон uok@nema.gov.mn цахим хаягт ирүүлнэ.

ДАРГА  Н.НОМТОЙБАЯР